



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галт дулаан ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/24/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын  
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 88095436 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн  
Захирал: Ч.Энхчимэг  
Утас: 77233030 Цахим хаяг: [info@cptaaudit.mn](mailto:info@cptaaudit.mn)

Аудитор: Б.Бүрэнжаргал  
Утас: 77233030 Цахим хаяг: [info@cptaaudit.mn](mailto:info@cptaaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/263  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ГАЛТ ДУЛААН”  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.МӨНХ-ОЧИР ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Галт дулаан” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Галт дулаан” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

“Могойн гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Цагаан-Уул сумын Галт дулаан ХХК-д худалдан авсан нүүрсний нийт үнэнд 50 хувийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 265.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлж ажиллаа.

**Бусад асуудлын хэсэг**

“Галт дулаан” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан 2023 оны бизнес төлөвлөгөөнд нийт орлогыг 697.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 649.7 сая төгрөгөөр, татвар төлөхийн өмнөх ашгийг 47.3 сая төгрөг байхаар баталж, 100.4 хувийн орлогын гүйцэтгэлтэй ажилласан байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6724040652

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	258,547,198.96	144,544,029.08
1.1.2	Дансны авлага	452,229,402.58	27,667,519.09
1.1.6	Бараа материал	63,304,814.60	61,912,889.09
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	774,081,416.14	234,124,437.26
1.2.1	Үндсэн хөрөнгө	847,828,383.79	1,605,957,755.82
1.2.2	Биет бус хөрөнгө	15,274,250.00	15,155,500.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	863,102,633.79	1,621,113,255.82
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,637,184,049.93</b>	<b>1,855,237,693.08</b>
2.1.1.1	Дансны өглөг	-	196,709,023.38
2.1.1.3	Татварын өр	-	8,636,754.44
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	205,345,777.82
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	53,162,458.66	44,615,930.33
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	53,162,458.66	44,615,930.33
2.2	Өр төлбөрийн нийт дүн	53,162,458.66	249,961,708.15
2.3.1	Өмч: - төрийн	894,273,469.00	894,273,469.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	416,402,033.53	416,402,033.53
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	14,968,000.00	14,968,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	258,378,088.74	258,378,088.74
2.3.10	Тайлант үеийн ашиг алдагдал	-	21,254,393.66
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,584,021,591.27	1,605,275,984.93
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,637,184,049.93	1,855,237,693.08

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	690,765,380.24	696,803,695.91
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	563,929,426.59	595,774,317.84
3	Нийт ашиг (алдагдал)	126,835,953.65	101,029,378.07
4	Түрээсийн орлого	3,536,363.64	3,245,454.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	56,650,744.00	65,809,266.00
11	Санхүүгийн зардал	143,600.00	147,400.00
12	Бусад зардал	-	10,000,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	73,577,973.29	28,318,166.62
19	Орлогын татварын зардал	60,520,255.99	7,063,772.96
20	Татварын дараах ашиг (алдагдал)	13,057,717.30	21,254,393.66

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
<b>2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл</b>	894,273,469.00	416,402,033.53	14,968,000.00	89,838,338.22	1,415,481,840.75
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	894,273,469.00	416,402,033.53	14,968,000.00	89,838,338.22	1,415,481,840.75
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	168,539,750.52	168,539,750.52
<b>2023 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл</b>	894,273,469.00	416,402,033.53	14,968,000.00	258,378,088.74	1,584,021,591.27
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	894,273,469.00	416,402,033.53	14,968,000.00	258,378,088.74	1,584,021,591.27
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	21,254,393.66	21,254,393.66
<b>2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл</b>	894,273,469.00	416,402,033.53	14,968,000.00	279,632,482.40	1,605,275,984.93

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	820,672,118.06	809,984,697.42
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	756,369,331.06	767,734,045.42
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	1,772,552.00
	Бусад мөнгөн орлого	64,302,787.00	40,478,100.00
1.2	Мөнгөн зарлага (-)	731,901,851.02	712,487,867.30
	Ажиллагчдад төлсөн	264,268,047.80	255,493,062.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	62,427,754.70	63,998,017.40
	Бараа материал худалдан авахад төлсөн	173,116,614.15	101,929,549.30
	Ашиглалтын зардалд төлсөн	23,589,356.64	124,643,055.20
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	36,938,522.00	41,930,939.99
	Татварын байгууллагад төлсөн	98,546,298.68	72,463,833.81
	Даатгалын төлбөрт төлсөн	-	676,793.00
	Бусад мөнгөн зарлага	73,015,257.05	51,352,616.60
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	88,770,267.04	97,496,830.12
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	211,500,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	211,500,000.00

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(211,500,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	88,770,267.04	(114,003,169.88)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	169,776,931.92	258,547,198.96
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	258,547,198.96	144,544,029.08

## 2.5 ТУЗ-аар батлагдсан Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл /төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэмнэлт хэтрэлт	Хувь
		Жилийн эхнээс	Жилийн эхнээс		
<b>1. Нийт борлуулалтын орлого</b>					
1.1	Халаалтын орлого	650,870,973.00	649,597,073.70	(1,273,899.30)	99.8
1.2	Халуун усны орлого	10,909,091.00	11,027,272.73	118,181.73	101.1
1.3	Цэвэр усны орлого	20,909,091.00	26,385,114.39	5,476,023.39	126.2
1.4	Хог тээвэр	10,909,091.00	9,724,135.09	(1,184,955.91)	89.1
1.5	Түрээсийн орлого	3,363,637.00	3,245,454.55	(118,182.45)	96.5
1.6	Бусад орлого	-	70,100.00	70,100.00	-
<b>Борлуулалтын орлогын дүн</b>		<b>696,961,883.00</b>	<b>700,049,150.46</b>	<b>3,087,267.46</b>	<b>100.4</b>
<b>2. Нийт зардал</b>					
2.1	Нийт цалин хөлс	252,431,566.00	255,979,379.00	3,547,813.00	101.4
2.2	Цалингийн НДШ	34,345,261.00	37,956,627.98	3,611,366.98	110.5
2.3	Нүүрсний зардал	80,100,000.00	49,452,050.00	(30,647,950.00)	61.7
2.4	Түлээний зардал	1,950,000.00	1,017,500.00	(932,500.00)	52.2
2.5	Нүүрс тээврийн зардал	48,060,000.00	50,851,090.91	2,791,090.91	105.8
2.6	Түлш шатахууны зардал	37,716,739.00	38,306,327.85	589,588.85	101.6
2.7	Цахилгааны зардал	32,728,768.00	27,035,168.36	(5,693,599.64)	82.6
2.8	Хөдөлмөр хамгааллын зардал	7,692,300.00	3,807,252.71	(3,885,047.29)	49.5
2.9	Бичиг хэргийн зардал	765,334.00	451,854.59	(313,479.41)	59.0
2.1	Интернэтийн зардал	338,400.00	222,363.64	(116,036.36)	65.7
2.11	Томилолтын зардал	280,000.00	-	(280,000.00)	-
2.12	Цэвэрлэгээний зардал	1,010,000.00	968,672.56	(41,327.44)	95.9
2.13	Сэлбэг хэрэгслийн зардал	16,653,000.00	9,780,000.00	(6,873,000.00)	58.7
2.14	Урсгал зардал	5,888,000.00	3,807,291.49	(2,080,708.51)	64.7
2.15	Төлбөр хураамж	9,653,037.00	16,252,751.36	6,599,714.36	168.4
2.16	Тэтгэмжийн зардал	31,090,440.00	27,603,373.21	(3,487,066.79)	88.8
2.17	Засвар үйлчилгээ зардал	1,937,500.00	1,877,719.37	(59,780.63)	96.9
2.18	Элэгдлийн зардал	77,025,486.00	80,744,215.43	3,718,729.43	104.8
2.19	Бусад зардал	2,079,318.00	47,656,436.38	45,577,118.38	2,291.9
2.20	ТУЗ-ийн зардал	6,910,500.00	6,900,000.00	(10,500.00)	99.8
2.21	Түрээсийн зардал	1,009,091.00	1,060,909.00	51,818.00	105.1
2.22	Хандив тусламж	-	10,000,000.00	10,000,000.00	-
<b>Нийт зардлын дүн</b>		<b>649,664,740.00</b>	<b>671,730,983.84</b>	<b>22,066,243.84</b>	<b>103.4</b>

	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал</b>	<b>47,297,143.00</b>	<b>28,318,166.62</b>	<b>(18,978,976.38)</b>	<b>59.9</b>
	Орлогын албан татварын зардал	2,364,857.00	7,063,772.96	4,698,915.96	298.7
	<b>Цэвэр ашиг алдагдал</b>	<b>44,932,286.00</b>	<b>21,254,393.66</b>	<b>(23,677,892.34)</b>	<b>47.3</b>

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 484.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14.6 сая төгрөгийн алдааг залруулж, 2.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 467.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй зөрчилтэй асуудлын материаллаг бус алдаа зөрчил нь 465.8 сая төгрөг, материаллаг алдаа 4.4 сая төгрөг тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Хог тээвэрлэдэг маяги машин шатсан талаар галын дүгнэлт гарсан бөгөөд тухайн машиныг санхүүгийн бүртгэлээс хасаагүй, элэгдлийг үргэлжлүүлэн тооцсон байсныг;
- НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын орлого, санхүүгийн тайлангаарх борлуулалтын орлогоос 14.1 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан

### 5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: 19,5 сая төгрөгийн цалин, урамшуулалд НДШ суутгаж олгоогүй 2,6 сая төгрөг байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 19.1.3-тай нийцэхгүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 19.1.3. “ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Албан шаардлага хүргүүлэх.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Анхан шатны баримт бүрдэлттэй холбоотой

Илрүүлэлт: Худалдан авалттай холбоотой 261.2 сая төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримттай боловч цахим и-баримтгүй байгаа нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.4; “доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.3.1. “Анхан шатны баримт бүрдүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг баталгаажуулж байх

#### 2. Цалин, НДШ-ийн зардалтай холбоотой

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланг бодогдсон цалингийн зардлаас 1.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" 17.1.3 "Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах" гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ерөнхий журнал дахь Цалин, НДШ-ийн зардлыг цалингийн хүснэгт, нийгмийн даатгалын тайлантай тулган хяналт тавих

### **3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой**

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 21 удаагийн 204.5 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг үнэн зөв мэдээлж байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлийн зардлыг илүү тооцоолсон	1	0.5			1	0.5	1	0.5		
Борлуулалтын орлогыг НӨАТ-н тайлан, санхүүгийн тайланд зөрүүтэй тайлагнасан	1	14.1			1	14.1	1	14.1		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>14.6</b>			<b>2</b>	<b>14.6</b>	<b>2</b>	<b>14.6</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТУЗ-ийн цалин, урамшууллаас НДШ суутгаагүй	1	2.6			1	2.6		
Нийгмийн даатгалын тайланг бодогдсон цалингийн зардлаас зөрүүтэй тайлагнасан	1	1.8					1	1.8
Худалдан авалттай холбоотой цахим и-баримтгүй гүйлгээ хийсэн	1	261.2					1	261.2
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>265.6</b>			<b>1</b>	<b>2.6</b>	<b>2</b>	<b>263.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 21 удаагийн мэдээллийг байршуулаагүй.	1	204.5					1	204.5
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>204.5</b>					<b>1</b>	<b>204.5</b>

**ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1				1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>				<b>1</b>			



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 03 сарын 15 өдөр

№ 59/20240439/2024-2024/  
24/АА-СИА-02АА

Мөрөн сум

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Галт дулаан ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Галт дулаан ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон ажиллагсад олгосон 19,500,000.0/арван есөн сая таван зуун мянга/ төгрөгийн цалин, урамшуулал, түлээний хөнгөлөлтөөс нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, нийгмийн даатгалын шимтгэлийн 2,585,000.0 /хоёр сая таван зуун наян таван мянга/ төгрөгийн зардал бүртгээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон ажиллагсад олгосон 19,500,000.0/арван есөн сая таван зуун мянга/ төгрөгийн цалин, урамшуулал, түлээний хөнгөлөлтөөс нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, нийгмийн даатгалын шимтгэлийн 2,585,000.0 /хоёр сая таван зуун наян таван мянга/ төгрөгийн зардал бүртгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Галт дулаан ХХК-ийн захирал Д.Мөнх-Очир, нягтлан бодогч Ч.Батчимэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Ч.ЭНХЧИМЭГ

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724030213